

**Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**



**Палеонтологи, геологийн
хүрээлэнгийн 2017 оны
санхүүгийн тайлан**

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Санхүүгийн Аудитын Газрын
захирал бөгөөд,

Тэргүүлэх аудитор

Ц.Наранчимэг

Утас: 263-533

Аудитын менежер: С.Оюунгэрэл

Утас: 261-885

Ахлах аудитор: Д.Цэрэндорж

Утас: 261-740

ТАБ-ын хаяг:

Үндэсний аудитын газар

Байршил: Улаанбаатар-46,

Чингэлтэй дүүрэг, Бага тойруу,

Засгийн газрын IV байр,

Цахим хуудас: www.audit.mn

Гүйцэтгэгч:

Ол дөш хайрхан-аудит ХХК

Захирал: А.Саранцэцэг

Утас: 99250679

И-мэйл: saraa_1303@yahoo.com

ахлах аудитор: Т.Сарантуяа

Утас: 99194484

И-мэйл: saraa_tu@yahoo.com

Хаяг: Хан-Уул дүүрэг,

3 дугаар хороо, ЭХБУТ

компанийн байр

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Акт

Хавсралт 5: Байгууллагаас ирүүлсэн хариу

Хавсралт 6: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлан

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ПАЛЕОНТОЛОГИ, ГЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: **САГ-2018/185/СТА-ТШЗ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2018 он



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/408
танай _____-ны № _____-т

ПАЛЕОНТОЛОГИ, ГЕОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
Х.ЦОГТБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дахь заалтад заасны дагуу Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт


Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.




Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, заалтын дагуу Үндэсний аудитын газрын захиалгаар Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд /САГ-2018/185/СТА-ТШЗ/ "Ол дөш хайрхан-Аудит" ХХК аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийлээ.

Палентологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Палентологи, геологийн хүрээлэн нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансны зааврын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Палентологи, геологийн хүрээлэнгийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь "Ол дөш хайрхан-Аудит" ХХК -ийн үүрэг юм.

Палентологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 24-нөөс 2018 оны 2 дугаар сарын 5-ны хооронд хийхээр төлөвлөн, "Ол дөш хайрхан-Аудит" ХХК-ийн ахлах аудитор Т.Сарантуяа, ахлах аудитор Ц.Бумцэнд, аудиторын туслах О.Эрдэнэбат нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг хийж гүйцэтгэв.

Аудитын тайлан, гэрчилгээг 2018 оны 2 дугаар сарын 20-нд Палеонтологи, геологийн хүрээлэнгийн удирдлагад хүргүүлээ.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Палеонтологи, геологийн хүрээлэн нь Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн, Нягтлан бодох бүртгэлийн, Хөдөлмөрийн, Нийгмийн даатгалын, ХХОАТ-ын, Соёлын өвийг хамгаалах тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Палеонтологи, геологи судлалын чиглэлээр онолын суурь судалгаа, судалгаа боловсруулалтын ажлыг орчин үеийн шинжлэх ухаан, техник технологийн түвшинд гүйцэтгэх, дэлхийн шинжлэх ухааны сан хөмрөгт өөрийн

**Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

хувь нэмрээ оруулах, нийгэмд шинэ мэдлэг мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх зорилготой байгууллага юм. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Монгол Улсад палеонтологи, геологийн суурь судалгааны чиглэлээр тэргүүлэн манлайлсан ШУА-ийн харьяа "Төв Азийн Геологи судлалын томоохон төв" болон "Эртний амьтан ургамлын судалгаа (палеонтологи)-ны олон улсын хүрээлэн (төв)" байгуулж, палеонтологи, геологийн чиглэлээр дэлхийд тэргүүлэх орон болно.
2. Судалгаа шинжилгээний ажлын болон инновацийн үйл ажиллагааны үр дүнгээрээ улс орныхоо нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна.
3. Гадаад дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлж түнш байгууллага, их дээд сургуулиудтай хамтарсан судалгааг нэмэгдүүлнэ. Орчин үеийн багаж тоног төхөөрөмжөөр техник технологийн шинэчлэл хийж, судалгаа шинжилгээний лабораторийн баазтай болно.
4. Шинжлэх ухаан, шинэ мэдлэгийг эрхэм болгосон, ажилтан, албан хаагчдын ажиллах, амьдрах бүхий л талын таатай орчин нөхцөлийг цогцлон бүрдүүлсэн эрдэм шинжилгээний байгууллага болно.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна", 16.4-т "Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна": 16.4.18-д "Төсвийн бусад байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн захирагч байна" гэж заасны дагуу Палеонтологи, геологийн хүрээлэнгийн захирал төсвийг захиран зарцуулж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 2017 төсвийг баталж, санхүүжилтийг төв төрийн сангаас олгож байна.

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 26-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагааг асуулга явуулах аргаар танилцсан. /ТАБ-СТА-В-2/

**Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн Acolous 3.0 програмаар боловсруулан, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Тус байгууллага төсвөөс 100 хувь санхүүжилт авдаг ба мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын дүнгээс 1 хувиар тооцож 17,689.2 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тогтоосон.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Палеонтологи, геологийн хүрээлэн нь дотоод хяналтын нэгж, ажилтан байхгүй учир байгууллагын санхүүгийн мөнгөн урсгалын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд тавих хяналт хангалтгүй байна.

Байгууллагын орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Палеонтологи, геологийн хүрээлэн 2017 онд улсын төсвөөс 895,026.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 8,000.0 мянган төгрөг, нийт 903,026.4 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэхээс улсын төсвөөс 895,026.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,449.0 мянган төгрөг, нийт 897,457.4 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 5,551.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

Гүйцэтгэлээр 893,635.1 мянган төгрөг төгрөг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн орлого 866,623.1 мянган төгрөг /үүнээс: үзэсгэлэнгийн орлогын урьд оны төвлөрүүлэлтээс буцаж орж ирсэн 598,048.9 мянган төгрөг, Таван толгой ХК-аас андуурч орж ирсэн 1,336.5 мянган төгрөг, ШУТСангаас төслийн санхүүжилт 160,914.9 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт санхүүжилтийн орлогоос 106,322.8 мянган төгрөг/ орсон. Эхний үлдэгдэл 8.0 мянган төгрөг байсан. Нэмэлт санхүүжилтийн орлогоос 267,030.6 мянган төгрөг зарцуулсан.

Нийт 603,440.8 мянган төгрөг төвлөрүүлснээс улсын төсвийн санхүүжилтээс 3,840.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлогоос 599,600.5 мянган төгрөг /үүнээс: нэмэлт санхүүжилтээс 215.1 мянган төгрөг, үзэсгэлэнгийн орлогын 598,048.9 мянган төгрөг, Таван толгой ХК-ийн андуурч орж ирсэн 1,336.5 мянган төгрөг/ тус тус төвлөрүүлжээ.

Шилэн дансны мэдээлэл:

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүгийн тайлан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан байна.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 26 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 26 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/ Үүнд:

Авлага данс: НДСангаас орж ирсэн тэтгэмжийг авахаар тооцсон үед НДС-гаас авах авлагыг бүртгээгүй, урьд онд төвлөрүүлээд авлагаар бүртгэсэн байсан бөгөөд тайлант онд буцаан авахад орлогоор бүртгэж,

Урьдчилж төлсөн зардлын данс: урьдчилж төлсөн зардал буцаж орж ирсэнийг орлогоор бүртгэсэн, хаагдаагүй үлдсэн урьдчилж төлсөн зардлыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй,

Үндсэн хөрөнгийн данс: үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тогтоолд заасан дүнгээс ерөнхий журнал дахь хуримтлагдсан элэгдэл, үлдэгдэл өртгийг зөрүүтэй бүртгэсэн, акталсан үндсэн хөрөнгийн ерөнхий журнал дахь дүн ТӨБЗГ-ын шийдвэрийн дүнгээс дутуу,

Бараа материалын данс: бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн, бараа материалыг багцлан бүртгэсэн,

Өглөг данс: цалингаас суутгасан ХХОАТ, НДШ-ийн бичилтийг хийгээгүй, санхүүгийн тайланд ХХОАТ-ын өглөгийг ерөнхий журналын дүнгээс дутуу тусгасан,

Цалингийн зардал данс: ээлжийн амралтын олговрын тооцоололыг хийхдээ унаа, хоолны хөнгөлөлтийг оруулан тооцсон,

АШБ хөтлөлт: агуулахын бүртгэл хөтөлдөггүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Энэ нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй юм.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний нийт 1,544,592.4 мянган төгрөгийн /авлага, урьдчилж төлсөн зардал, бараа материал, өглөг, үндсэн хөрөнгө, цалин хөлс зэрэг дансанд/ мөнгөн урсгалын ажил гүйлгээ, үлдэгдэл тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 87.0 хувь, нийт зардлын 87.3 хувь, нийт хөрөнгийн 42.6 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудын дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний нийт 823,274.2 мянган төгрөгийн дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. НДСангаас орж ирсэн 10,311.1 мянган төгрөгийн тэтгэмжийг авахаар тооцсон үед НДС-гаас авах авлага, хувь хүнд өгөх өглөгөөр бүртгэх бичилтийг буруу хийсэн. /зөвхөн өглөгөөр бүртгэсэн/

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

01

ТӨРМӨН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЭТ

**Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

2. Урьд онд төвлөрүүлсэн 598,048.9 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байсан бөгөөд тайлант онд буцаан авахад орлогоор бүртгэж, дансны бичилт буруу хийсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

3. Урьдчилж төлсөн 29,520.0 мянган төгрөгийн зардал буцаж орж ирсэнийг орлогоор бүртгэж, дансны бичилт буруу хийсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

4. Урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл 10,229.5 мянган төгрөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

5. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолд заасан дүнгээс ерөнхий журнал дахь хуримтлагдсан элэгдлийн нийт дүнг 7,714.4 мянган төгрөгөөр илүү бүртгэснээр үлдэгдэл өртөг энэ дүнгээр дутуу бүртгэгдсэн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

6. Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: ТӨБЗГ-аас зөвшөөрөл авч, залруулах бичилтийг хөрөнгийн дахин үнэлгээнээс өмнө хийх.

7. 20,643.90 мянган төгрөгийн бараа материалыг багцлан бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө тус бүрээр задлан бүртгүүлэв.

8. Цалингаас суутгасан 79,568.1 мянган төгрөгийн НДШ-ийн бичилтийг "НДШ-ийн өглөг" дансны КТ-ээс "Цалингийн өглөг" дансны ДТ-д бичих байтал "Цалингийн зардал" дансны ДТ-д бичсэн.

Шийдвэрлэсэн нь: Залруулга хийлгэв.

9. Цалингаас суутгасан 63,699.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын бичилтийг "ХХОАТ-ын өглөг" дансны КТ-ээс "Цалингийн өглөг" дансны ДТ-д бичих байтал "Цалингийн зардал" дансны ДТ-д бичсэн.

Шийдвэрлэсэн нь: Залруулга хийлгэв.

10. Санхүүгийн тайланд 940.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг ерөнхий журналын дүнгээс дутуу тусгасан.

Шийдвэрлэсэн нь: Залруулга хийлгэв.

11. Ээлжийн амралтын олговрын тооцооллыг хийхдээ унаа, хоолны хөнгөлөлтийг оруулан тооцоноос 2,148.0 мянган төгрөг илүү олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

12. Орон тоог албан тушаал бүрээр батлаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

13. Үр дүнгийн гэрээний биелэлтээр олгож буй урамшууллыг үрчлэвчийн нэмэгдэл гэж тушаалыг буруу гаргаж байна.



Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

14. Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн гэж 450.0 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

15. Агуулахын бүртгэл хөтөлдөггүй

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.



**Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Хууль, эрхийн актуудыг зөрчсөнөөс үүссэн ээлжийн амралтын олговрын тооцоололыг хийхдээ унаа, хоолны хөнгөлөлтийг оруулан тооцсон, жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн гэж нэмэгдэл хөлс олгосон, урьдчилж төлсөн зардлын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй. Нийт 12,828.1 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Үзэсгэлэнгийн орлогоос орж ирсэн 598,048.9 мянган төгрөгийг Сангийн яаманд сүүлийн 3 жил дараалан төвлөрүүлж, авлага үүсгэдэг, энэ байдлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрүүлэх шаардлагатай байна

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй өөр бусад эрсдэлтэй асуудлууд гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:


Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 823,274.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 810,446.1 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 12,828.1 мянган төгрөгийн зөрчилөөс 2598,6 мянган төгрөгт төлбөрийн акт бичиж, 10229,5 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“И эс эс эс аудит” ХХК нь Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж, 3 зөвлөмж өгснөөс 2 нь хэрэгжсэн байна. Үүнд:


1. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 270 дугаар тогтоолын дагуу 2017 оны 9 дугаар сарын 25-наар Баянзүрх дэх ШУА-ийн 8 дугаар байрыг Баянзүрх дүүргийн прокурорын газарт шилжүүлсэн байна.
2. 2017 оны 12 дугаар сарын 19-ны 598,048.9 мянган төгрөгийг / Сангийн яамны Төрийн сангийн даргын 2014 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 9-2/3520 дугаар албан бичгээр “Төрийн сангийн нэгдсэн дансанд орлого төвлөрүүлэх зориулалттай үзэсгэлэнгийн орлого”-ын 900015901 дугаар дансанд/ шилжүүлсэн.

Харин Үлэг гүрвэлийн төв музей байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол гарсны дагуу Байгалийн түүхийн музейд дэлгэн үзүүлж байсан ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнгийн үлэг гүрвэлийн олдвор цуглуулгыг шилжүүлэх тухай шийдвэр хэрэгжээгүй хэвээр байна.



Зөрчилгүй санал дүгнэлт

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон тодруулгад тайлагнасан



Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

үлдэгдэл, ажил гүйлгээнүүд нь холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна

АУДИТЫН ТАЙЛАНГ


Бэлтгэсэн:

Ахлах аудитор



Ц.Бумцэнд

Аудиторын туслах



О.Эрдэнэбат

Хянасан:

Захирал/аудитор/



А.Саранцэцэг

Чанарын хяналт хариуцсан аудитор



Т.Сарантуяа

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Палентологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Палентологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны
санхүүгийн тайлан

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Авлага

Асуудал 2

Урьдчилж төлсөн зардал

Асуудал 3

Үндсэн хөрөнгө

Асуудал 4

Бараа материал

Асуудал 5

Өглөг

Асуудал 6

Цалингийн зардал

суудал 7

Анхан шатны баримт

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2018 оны 02 дугаар сар

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

"Ол дөш хайрхан аудит" ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Палентологи, геологийн хүрээлэнгийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг "Ол дөш хайрхан аудит" ХХК-ийн аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

"Ол дөш хайрхан аудит" ХХК энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Палентологи, геологийн хүрээлэнгийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Палентологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Асуудал 1: Авлага	Тэргүүлэх ач холбогдол №1
-------------------	---------------------------

НАГ-ын ажиглалт

НДСангаас орж ирсэн 10,311.1 мянган төгрөгийн тэтгэмжийг авахаар тооцсон үед НДС-гаас авах авлага, хувь хүнд өгөх өглөгөөр бүртгэх бичилтийг буруу хийсэн. /зөвхөн өглөгөөр бүртгэсэн/

Урьд онд төвлөрүүлсэн 598,048.9 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байсан бөгөөд тайлант онд буцаан авахад орлогоор бүртгэж, дансны бичилт буруу хийсэн.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

НАГ-ын зөвлөмж

Залруулах бичилт хийх

Залруулах бичилт хийх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн алдааг зөвшөөрч, байгууллагын удирдлага санхүүгийн тайландаа залруулга хийсэн болно.

Асуудал 2: Урьдчилж төлсөн зардал	Тэргүүлэх ач холбогдол №1
-----------------------------------	---------------------------

НАГ-ын ажиглалт

Урьдчилж төлсөн 29,520.00 мянган төгрөгийн зардал буцаж орж ирсэнийг орлогоор бүртгэж, дансны бичилт буруу хийсэн.

Урьдчилж төлсөн 10229,5 мянган төгрөгийн зардлыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй.

Эрсдэлүүд



Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

НАГ-ын зөвлөмж

Залруулах бичилт хийх

Зөрчлийг арилгах

Үйлчлүүлэгчийн хариу
Аудитаар илэрсэн алдааг зөвшөөрч, байгууллагын удирдлага санхүүгийн тайландаа залруулга хийсэн, зөрчлийг арилагасан болно.



Палентологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Асуудал 3: Үндсэн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №1
---------------------------	---------------------------

НАГ-ын ажиглалт

Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолд заасан дүнгээс ерөнхий журнал дахь хуримтлагдсан элэгдлийн нийт дүнг 7,714.4 мянган төгрөгөөр илүү, үлдэгдэл өртгийг 7,714.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн.

Эрсдэлүүд

Үндсэн хөрөнгийг санхүүгийн үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

НАГ-ын зөвлөмж

Зөрчлийг давтан гаргахгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу

Засгийн газрын тогтоол 2016 онд гарсан боловч хөрөнгийг 2017 оны 9-р сард шилжүүлэх хүртэл элэгдэл тооцож байснаас зөрүү үүссэн. 965.4 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаагүй. ТӨБЗГ-т санал явуулахдаа тоог тонгоруулж бичсэнээс 18.0 мянган төгрөгийн зөрүү үүссэн. Зөрчлийг давтан гаргахгүй.

Асуудал 4: Бараа материал	Тэргүүлэх ач холбогдол №1
---------------------------	---------------------------

НАГ-ын ажиглалт

Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн.

20,643.90 мянган төгрөгийн бараа материалыг багцлан бүртгэсэн.


Эрсдэлүүд

Бараа материалыг санхүүгийн тайланд үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

НАГ-ын зөвлөмж


ТӨБЗГ-аас зөвшөөрөл авч, залруулах бичилтийг дахин хөрөнгийн үнэлгээнээс өмнө хийх.

Хөрөнгө тус бүрээр задлан бүртгэх



Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн алдааг зөвшөөрч, байгууллагын удирдлага санхүүгийн тайландаа залруулга хийсэн болно.



Палентологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Асуудал 5: Өглөг	Тэргүүлэх ач холбогдол №1
------------------	---------------------------

НАГ-ын ажиглалт

Цалингаас суутгасан 79,568.1 мянган төгрөгийн НДШ-ийн бичилтийг "НДШ-ийн өглөг" дансны КТ-ээс "Цалингийн өглөг" дансны ДТ-д бичих байтал "Цалингийн зардал" дансны ДТ-д бичсэн.

Цалингаас суутгасан 63,699.10 мянган төгрөгийн ХХОАТ-ын бичилтийг "ХХОАТ-ын өглөг" дансны КТ-ээс "Цалингийн өглөг" дансны ДТ-д бичих байтал "Цалингийн зардал" дансны ДТ-д бичсэн.

Санхүүгийн тайланд 940.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг ерөнхий журналын дүнгээс дутуу тусгасан.

НАГ-ын зөвлөмж

Залруулах бичилт хийх

Залруулах бичилт хийх

Залруулах бичилт хийх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн алдааг зөвшөөрч, байгууллагын удирдлага санхүүгийн тайландаа залруулга хийсэн болно.

Асуудал 6: Цалингийн зардал	Тэргүүлэх ач холбогдол №1
-----------------------------	---------------------------

НАГ-ын ажиглалт


Ээлжийн амралтын олговрын тооцооллыг хийхдээ унаа, хоолны хөнгөлөлтийг оруулан тооцоноос 2,148.0 мянган төгрөг илүү олгогдсон.

Орон тоог албан тушаал бүрээр батлаагүй байна.

Үр дүнгийн гэрээний биелэлтээр олгож буй урамшууллыг ур чадварын нэмэгдэл гэж тушаалыг буруу гаргаж САГ-2018/185/СТА-ТШЗ

НАГ-ын зөвлөмж

Төлбөрийн акт тогтоох



Зөрчлийг арилгах

Зөрчлийг арилгах



Палентологи, геологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

байна.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллого
хийсэн гэж 450.0 мянган төгрөгийн
нэмэгдэл хөлс олгосон.

Төлбөрийн акт тогтоох

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан үнэн зөв
илэрхийлэгдэхгүй байх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн алдааг зөвшөөрч,
зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж
ажиллана.

Асуудал 7: Анхан шатны баримт

Тэргүүлэх ач холбогдол №1

НАГ-ын ажиглалт

Агуулахын бүртгэл хөтөлдөггүй.

НАГ-ын зөвлөмж

Зөрчлийг арилгах

Эрсдэлүүд

Хөрөнгийн бүртгэл буруу хийгдэж,
улмаар санхүүгийн тайланд үнэн зөв
илэрхийлэгдэхгүй байх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн алдааг зөвшөөрч,
зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж
ажиллана.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОРЫН ТУСЛАХ

АХЛАХ АУДИТОР

Эрдэнэбат
Ц.Бумцэнд

О.ЭРДЭНЭБАТ

Ц.БУМЦЭНД

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1	765,810,175.85	846,139,877.01
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	31	8,000.00	(0.00)
Кассанд байгаа бэлэн мөнгө	311	8,000.00	0.00
Төгрөг	31110	0.00	0.00
Нэмэлт санхүүжилт	31130	8,000.00	-
Банкинд байгаа бэлэн мөнгө	312	-	(0.00)
Төгрөг	3121	-	(0.00)
Төрийн сангийн харилцах	31211	-	(0.00)
АВЛАГА	33	599,257,739.39	599,385,370.39
Бусад авлага	335	599,257,739.39	599,385,370.39
Татаас санхүүжилтийн авлага	33300	599,257,739.39	599,385,370.39
УРЬДЧИЛГАА	34	14,401,745.00	40,232,882.00
Урьдчилж гарсан зардал	34600	483,332.00	40,232,882.00
Урьдчилгаа тооцоо	3471	13,918,413.00	-
Томилолтын урьдчилгаа	34714	13,918,413.00	-
БАРАА МАТЕРИАЛ	35	152,142,691.46	206,521,624.62
Түүхий эд материал	351	10,268,488.18	11,347,788.18
Тусгай зориулалттай материал	35110	10,268,488.18	11,347,788.18
Хангамжийн материал	354	141,874,203.28	195,173,836.44
Бичиг хэргийн материал	35410	7,713,140.00	10,187,540.00
Аж ахуйн материал	35420	83,882,915.28	133,010,863.44
Сэлбэг хэрэгсэл	35430	450,000.00	1,230,000.00



Барилгын засварын материал	35450	2,000,500.00	2,058,500.00
Бусад хангамжийн материал	35470	47,827,648.00	48,686,933.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2	2,815,680,263.86	2,778,029,637.20
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	39	2,815,680,263.86	2,778,029,637.20
Биет хөрөнгө	392	2,814,639,847.13	2,777,520,887.07
Барилга, байгууламж	39201	1,232,151,373.00	817,570,218.00
Хуримтлагдсан элэгдэл	39202	(631,861,290.48)	(251,678,681.47)
Авто тээврийн хэрэгсэл	39203	104,351,780.00	104,351,780.00
Хуримтлагдсан элэгдэл	39204	(94,157,762.00)	(102,245,879.48)
Машин, тоног төхөөрөмж	39205	945,089,644.00	965,380,830.00
Хуримтлагдсан элэгдэл	39206	(889,348,589.67)	(895,859,011.73)
Тавилга, аж ахуйн эд хогшил	39207	118,892,692.32	119,050,092.32
Хуримтлагдсан элэгдэл	39208	(79,696,818.71)	(87,324,164.21)
Түүх соёлын дурсгалт зүйлс	39213	2,100,901,905.00	2,100,901,905.00
Бусад үндсэн хөрөнгө	39214	112,026,190.00	112,026,190.00
Хуримтлагдсан элэгдэл	39215	(108,943,413.38)	(109,886,528.41)
Номын фонд	39217	5,234,137.05	5,234,137.05
Биет бус хөрөнгө	393	1,040,416.73	508,750.13
Програм хангамж	39301	3,595,000.00	3,595,000.00
Хасагдуулга	39302	(2,554,583.27)	(3,086,249.87)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3	3,581,490,439.71	3,624,169,514.21
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	4	-	2,169,492.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	41	-	2,169,492.00
Өглөг	413	-	2,169,492.00
Бусад өглөг	4136	-	2,169,492.00

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Байгууллагад төлөх өглөг	41361	-	2,169,492.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	5	3,581,490,439.71	3,622,000,022.21
Засгийн газрын хувь оролцоо	51	3,581,490,439.71	3,622,000,022.21
Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	511	1,333,002,809.00	1,333,002,809.00
Өмч: -Төрийн өмч	51101	1,333,002,809.00	1,333,002,809.00
Хуримтлагдсан үр дүн	512	609,395,009.79	649,904,592.29
Өмнөх үеийн үр дүн	51210	609,395,009.79	609,395,009.79
Тайлант үеийн үр дүн	51220	-	40,509,582.50
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	51300	1,639,092,620.92	1,639,092,620.92
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	6	3,581,490,439.71	3,624,169,514.21

СТ-2А

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,065,144,090.00	1,181,818,200.16
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,642,680.00	19,554,032.00
Нийтлэг татварын бус орлого	8,642,680.00	19,554,032.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,642,680.00	19,554,032.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,810,550.00	2,449,032.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,832,130.00	17,105,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,056,501,410.00	1,162,264,168.16
Улсын төвлөрсөн төсвөөс	889,747,300.00	895,026,400.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	889,747,300.00	895,026,400.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		

01
 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
 ЗӨРЧИЛГҮЙ
 САНАЛ ДҮГНЭЛТ

01
 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
 ЗӨРЧИЛГҮЙ
 САНАЛ ДҮГНЭЛТ

	166,754,110.00	267,237,768.16
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	19,000,000.00	160,915,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	147,754,110.00	106,322,768.16
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	890,140,798.36	1,128,777,475.21
УРСГАЛ ЗАРДАЛ	888,940,798.36	1,097,524,061.60
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	888,940,798.36	1,097,524,061.60
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	650,261,143.96	716,625,425.43
Цалин	646,961,143.96	596,911,396.43
Нэмэгдэл цалин	-	69,074,530.00
Унаа хоолны хөнгөлөлт	-	27,289,500.00
Гэрээтийн цалин	3,300,000.00	23,349,999.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,102,065.18	79,128,333.39
Тэтгэврийн даатгалын шимтгэл	48,392,223.29	52,290,160.89
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,341,968.39	5,367,634.49
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	6,677,460.49	6,709,543.13
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,335,492.09	1,341,908.65
Эрүүл мэндийн даатгалын хураамж	13,354,920.92	13,419,086.23
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,585,696.83	23,648,869.00
Гэрэл цахилгааны зардал	11,310,150.98	7,956,600.60
Түлш, халаалтын зардал	19,500,896.85	13,530,202.60
Цэвэр, бохир усны зардал	1,774,649.00	2,162,065.80
Хангамж, бараа материалын зардал	4,800,257.51	5,558,575.03
Бичиг хэргийн материал		14,290.00
Тээвэр, шатахууны зардал	945,868.00	20,000.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	2,862,279.51	3,539,485.03

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ
945,868.00 20,000.00

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Ном, хэвлэлийн зардал	-	510,800.00
Хог хаягдал устгах, цэвэрлэх	900,000.00	1,420,000.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	92,310.00	54,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,068,000.00	164,500.00
Урсгал засвар	1,068,000.00	164,500.00
Томилолт, зочны зардал	37,419,322.00	82,033,936.00
Гадаад томилолтын зардал	1,102,060.00	4,000,000.00
Дотоод томилолтын зардал	36,317,262.00	78,033,936.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	38,285,453.03	116,082,058.54
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,998,055.03	114,360,560.54
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	-
Даатгалын үйлчилгээний төлбөр	98,010.00	301,100.00
Тээврийн хэрэгслийн татвар	187,000.00	472,410.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	55,000.00
Газрын төлбөр	1,002,388.00	892,988.00
Бараа үйлчилгээний бусад зардал	49,418,859.85	74,282,364.21
Бараа үйлчилгээний бусад зардал	43,529,455.59	10,281,680.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,889,404.26	64,000,684.21
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,200,000.00	31,253,413.61
Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	27,197,953.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	4,985,952.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,200,000.00	22,212,001.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	01	ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 4,055,460.61
Төвлөрүүлэх шилжүүлэг	01	ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЭЛ 4,055,460.61
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	175,003,291.64	53,040,724.95

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЭЛ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	12,531,142.45
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		12,531,142.45
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)		(12,531,142.45)
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	175,003,291.64	40,509,582.50

СТ-3А

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,060,319,775.95	1,809,522,008.55
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,818,365.95	32,665,774.00
Нийтлэг татварын бус орлого	3,818,365.95	32,665,774.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,818,365.95	32,665,774.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,818,365.95	2,449,032.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	30,216,742.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,056,501,410.00	1,776,856,234.55
Улсын төвлөрсөн төсвөөс	889,747,300.00	895,026,400.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	889,747,300.00	895,026,400.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	166,754,110.00	871,518,738.55
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	19,000,000.00	160,915,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	147,754,110.00	710,603,738.55
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	10,311,096.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		10,311,096.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	998,655,500.63	1,804,030,008.55
УРСГАЛ ЗАРДАЛ	998,655,500.63	1,804,030,008.55
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	997,455,500.63	1,173,391,224.55
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	708,786,163.07	726,936,521.43

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАМ ДҮГНЭЭЛТ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАМ ДҮГНЭЭЛТ

Үндсэн цалин		607,222,492.43
Нэмэгдэл	-	69,074,530.00
Унаа хоолны хөнгөлөлт	-	27,289,500.00
Гэрээт ажлын хөлс	12,150,000.00	23,349,999.00
Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	77,260,265.19	79,128,333.39
Тэтгэврийн даатгалын шимтгэл	50,550,423.29	54,512,597.25
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,341,968.39	4,923,147.22
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	6,677,460.49	6,153,934.04
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,335,492.09	1,230,786.83
Эрүүл мэндийн даатгалын хураамж	13,354,920.93	12,307,868.05
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	33,794,565.83	22,440,000.00
Гэрэл цахилгааны зардал	12,519,019.98	6,747,731.60
Түлш, халаалтын зардал	19,500,896.85	13,530,202.60
Цэвэр, бохир усны зардал	1,774,649.00	2,162,065.80
Хангамж, бараа материалын зардал	6,073,424.51	8,788,673.03
Бичиг хэрэг	818,535.00	875,990.00
Тээвэр, шатахуун	1,368,000.00	680,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,862,279.51	2,706,493.03
Ном, хэвлэл	-	1,552,800.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900,000.00	1,420,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	124,610.00	1,553,390.00
Нормативт зардал	1,967,700.00	1,800,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,967,700.00	1,800,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	7,240,100.00	55,859,048.16

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Багаж техник хэрэгсэл	-	29,520,000.00
Тавилга	-	1,209,900.00
Урсгал засвар	7,240,100.00	25,129,148.16
Томилолт, зочны зардал	72,466,835.00	74,376,943.00
Гадаад албан томилолт	1,102,060.00	4,000,000.00
Дотоод албан томилолт	71,364,775.00	70,376,943.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,474,832.03	160,809,373.54
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	72,187,434.03	159,087,875.54
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	-
Даатгалын үйлчилгээ	98,010.00	301,100.00
Тээврийн хэрэгслийн татвар	187,000.00	472,410.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	55,000.00
Газрын төлбөр	1,002,388.00	892,988.00
Бараа үйлчилгээний бусад зардал	15,391,615.00	43,252,332.00
Бараа үйлчилгээний бусад зардал	15,391,615.00	43,252,332.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,200,000.00	630,638,784.00
Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	27,197,953.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	4,985,952.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,200,000.00	22,212,001.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	603,440,831.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	603,440,831.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	61,664,275.32	5,492,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	8,453,600.00	5,500,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,453,600.00	5,500,000.00

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Дотоод эх үүсвэрээр	8,453,600.00	5,500,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал /ТӨҮГ/	8,453,600.00	5,500,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(8,453,600.00)	(5,500,000.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	53,210,675.32	(8,000.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	8,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	606,259,545.71	-

СТ-4А

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,333,002,809.00	1,639,092,620.92	609,395,009.79	3,581,490,439.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,333,002,809.00	1,639,092,620.92	609,395,009.79	3,581,490,439.71
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	00.00	00.00	00.00	00.00
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	00.00	00.00	00.00	00.00
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,333,002,809.00	1,639,092,620.92	649,904,592.29	3,622,000,022.21

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	/төгрөгөөр/ ЗӨРҮҮ
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	903,026,300.00	893,635,114.24	9,391,185.76
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	903,026,300.00	893,635,114.24	9,391,185.76
Бараа, үйлчилгээний зардал	873,440,300.00	867,874,161.24	5,566,138.76
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	692,975,400.00	692,975,426.43	(26.43)
Үндсэн цалин	595,462,400.00	596,611,396.43	(1,148,996.43)
Нэмэгдэл	67,091,800.00	69,074,530.00	(1,982,730.00)
Унаа, болон бусад нөхөн олговор	30,421,200.00	27,289,500.00	3,131,700.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,933,400.00	76,038,799.39	2,894,600.61
Тэтгэврийн даатгал	78,933,400.00	51,423,063.25	27,510,336.75
Тэтгэмжийн даатгал	-	4,923,147.22	(4,923,147.22)
ҮОМШӨ ний даатгал	-	6,153,934.04	(6,153,934.04)
Ажилгүйдлийн даатгал	-	1,230,786.83	(1,230,786.83)
Эрүүл мэндийн даатгал	-	12,307,868.05	(12,307,868.05)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,400,000.00	22,400,000.00	-
Гэрэл цахилгаан	7,200,000.00	6,747,731.60	452,268.40
Түлш, халаалт	13,900,000.00	13,530,202.60	369,797.40
Цэвэр, бохир ус	1,300,000.00	2,122,065.80	(822,065.80)
Хангамж, бараа материалын зардал	5,870,000.00	4,688,582.42	1,181,417.58
Бичиг хэрэг	400,000.00	346,500.00	53,500.00
Тээвэр (шатахуун)	1,320,000.00	660,000.00	660,000.00
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,640,000.00	2,382,272.42	257,727.58
Ном, хэвлэл	250,000.00	200,000.00	50,000.00

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САЛГАЛТЫН ДҮН

Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	130,000.00	160,000.00	(30,000.00)
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,130,000.00	939,810.00	190,190.00
Нормативт зардал	1,800,000.00	1,800,000.00	-
Нормын хувцас зөөлөн эдлэл	1,800,000.00	1,800,000.00	-
Эд хогшил худалдан авах	50,000,000.00	49,988,730.00	11,270.00
Багаж, техник, хэрэгсэл	35,000,000.00	35,020,000.00	(20,000.00)
Урсгал засвар	15,000,000.00	14,968,730.00	31,270.00
Томилолт, зочны зардал	19,209,000.00	17,893,593.00	1,315,407.00
Дотоод албан томилолт	19,209,000.00	17,893,593.00	1,315,407.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,252,500.00	2,089,030.00	163,470.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,000.00	925,942.00	74,058.00
Даатгалын үйлчилгээ	98,100.00	98,100.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	187,000.00	187,000.00	-
Тээврийн хэрэгслийн оношилгоо	90,000.00	55,000.00	35,000.00
Газрын төлбөр	877,400.00	822,988.00	54,412.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,586,000.00	25,760,953.00	3,825,047.00
Бусад урсгал шилжүүлэг	29,586,000.00	25,760,953.00	3,825,047.00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,986,000.00	4,985,952.00	48.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	24,600,000.00	20,775,001.00	3,824,999.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	903,026,400.00	893,635,114.24	9,391,285.76
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	895,026,400.00	891,186,082.24	3,840,317.76
Улсын төсвөөс санхүүжих	895,026,400.00	891,186,082.24	3,840,317.76
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,000,000.00	2,449,032.00	5,550,968.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	2,449,032.00	5,550,968.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНГАЛ ДҮГНЭЛТ

011 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНГАЛ ДҮГНЭЛТ

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(0.00)	0.00
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	82.00	82.00	
Удирдах ажилтан	1.00	1.00	
Гүйцэтгэх ажилтан	58.00	58.00	
Үйлчлэх ажилтан	23.00	23.00	

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**